

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 – 5

1. *Байнгын хорооны тогтоолын төсөл /Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээр бүртгэх тухай/*

4 – 5

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны 12 дугаар сарын 11-ний өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 20 цаг 32 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Х.Баасанжаргал, Б.Пүрэвдорж;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баттулга, Л.Мөнхбаатар;

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээр бүртгэх тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

“Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээр бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.6-д заасны дагуу “Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээр бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: “Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээр бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 20 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 03 минут үргэлжилж, 22 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 72.7 хувийн ирцтэйгээр 20 цаг 35 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
20 цаг 32 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Би нэг тайлбар хийе. Төсвийн хэлэлцүүлэгтэй давхацсан байгаа учраас маргааш 11.00 цаг хүртэл гээд түр хойшлуулчихсан байсан.

Гэхдээ гишүүдийн ирц бүрдэж байгаа учир маргаашийн 11.00 цаг биш одоо шууд өнөөдөр 12 сарын 11-дээ энэ хурлаа буцааж нээгээд үргэлжлүүлээд явж байна.

Ингээд Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн. 54.5 хувь дээрээ явж байгаа. Түрүүн ирсэн гишүүдийн ирцийг танилцуулсан байгаа.

Гишүүдийн олонх хүрч ирсэн. Ирц 54.5 хувьтай байгаа.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу ирцийг танилцууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг л асуудал байгаа.

Байнгын хорооны тогтоолын төсөл.

Санхүүгийн зохицуулах хорооны хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг дэвшүүлэх асуудалтай холбоотой нэг асуудал байгаа.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Санхүүгийн зохицуулах хорооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчээр бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тогтоолын төслийг Та бүхэнд тараасан байгаа.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.
/алх цохив/

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.6 дахь хэсэгт Байнгын хороо хуульд заасны дагуу албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэхдээ гишүүдээс санал болгосон нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар нэр дэвшүүлэхийг дэмжсэнд тооцно гэж заасны дагуу Байнгын хорооноос нэр дэвшүүлэх иргэнийг сонгох зорилтын хүрээнд Байнгын хорооны тогтоолоор нэр дэвшигчээр бүртгэх зарыг нийтэд нээлттэй мэдээлж, шалгаруулах ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзээд “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хороогоор хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

Сайхан амарцгаагаарай. Х.Баасанжаргал гишүүндээ би бас баяр хүргэмээр байна. С.Эрдэнэболд гишүүндээ баяр хүргэмээр байна.

Өөрийнхөө байр суурь дээр бас хатуу зогсож чадсаныг энэ Байнгын хорооны протоколд тэмдэглэж үлдээмээр байна.

Хуралдаан 3 минут үргэлжилж, 20 цаг 35 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД